



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/320/НА-СТА-ТШЗ

Цахим www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	хуудас:	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 260512 Цахим хаяг: erdenetsetsegi@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Лхагвацэнд Утас: 261628 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Анализ старт аудит ХХК-ийн захирал Н.Энхтуяа Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
---	---------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж.....	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
САГ	Санхүүгийн аудитын газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот. 15160
Утас: 26 04 37. Факс: (976-51) 26 42 30.
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.05 № 06/518
танай _____-ны № _____-т

ХАРХОРИН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.САЙНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 246,196.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй 18,900.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн;
- Төсвийг зориулалт бусаар зарцуулж, ажилчдад цалингийн зардлаас 48,000.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон;
- Нягтлан бодох бүртгэлд анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэлгүй, бүрэн бус хангалтгүй баримтыг үндэслэн 36,155.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж, зардалд бүртгэсэн;
- Худалдан авах ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, төсөвт өртгийг хувааж, шууд гэрээ байгуулан нийт 39,000.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд байна.

Дээрх зөрчлүүд нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2, Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 31 дүгээр зүйлийн 31.1 заалтуудтай тус тус нийцэхгүй, УСНББОУС 1, ", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлан бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллага нь тайлант онд өөрчлөн байгуулагдсан бөгөөд албан хаагчдын цалин хөлсийг төрийн албан хаагчийн цалингийн сүлжээгээр тогтоон мөрдөөгүй, байгууллагын дотоод журмын дагуу олгож байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Аудитын явцад шаардлагатай мэдээлэл, баримт материалыг хугацаанд нь бүрэн ирүүлээгүйгээс аудитын үйл ажиллагаанд тодорхой хүндрэл үүссэнийг тэмдэглэж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	20,387,665,660.22	20,250,539,312.51
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,238,067,166.25	20,217,694,819.64
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	20,238,067,166.25	20,217,694,819.64
31210	Төгрөг	20,238,067,166.25	20,217,694,819.64
31211	Төрийн сангийн харилцах	20,238,067,166.25	20,217,694,819.64
33	АВЛАГА	3,956,240.97	3,956,240.97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,956,240.97	-
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	-	3,956,240.97
35	БАРАА МАТЕРИАЛ	145,642,253.00	28,888,251.90
35100	Түүхий эд материал	-	313,400.00
35110	Тусгай зориулалттай материал	-	313,400.00
35400	Хангамжийн материал	145,642,253.00	28,574,851.90
35410	Бичиг хэргийн материал	6,118,703.00	6,624,618.90
35420	Аж ахуйн материал	-	8,173,391.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	5,367,342.00
35440	Түлш, шатах тослох материал	1,930,000.00	2,075,000.00
35470	Бусад хангамжийн материал	137,593,550.00	6,334,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	296,769,652.62	463,585,562.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	296,769,652.62	463,585,562.50
39200	Биет хөрөнгө	292,663,902.58	460,200,068.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,666,666.62	.
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	293,422,714.00	417,815,445
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,743,247.18	-143,306,490.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,845,130.00	179,959,653
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,194,027.62	-15,878,539.7
39217	Ном	-	1,610,000.00
39300	Биет бус хөрөнгө	4,105,750.04	3,385,494.44
39301	Програм хангамж	8,340,200.00	10,210,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,234,449.96	-6,824,705.56

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	20,684,435,312.84	20,714,124,875.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,190,588,000.00	20,102,416,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,190,588,000.00	20,102,416,000.00
41300	Өглөг	20,190,588,000.00	20,102,416,000.00
41360	Бусад өглөг	20,190,588,000.00	20,102,416,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	20,190,588,000.00	20,102,416,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	493,847,312.84	611,708,875.01
51	Засгийн газрын хувь оролцоо	493,847,312.84	611,708,875.01
51200	Хуримтлагдсан үр дүн	493,847,312.84	611,708,875.01
51210	Өмнөх үеийн үр дүн	394,422,450.14	493,847,312.84
51220	Тайлант үеийн үр дүн	99,424,862.70	117,861,562.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	20,684,435,312.84	20,714,124,875.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,355,585,026.48	5,644,072,511.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	325,349,989.48	5,644,072,511.04
120	Нийтлэг татварын бус орлого	325,349,989.48	291,814,786.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	560,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	560,000.00
120009	Бусад орлого	325,349,989.48	291,254,786.74
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	151,724,324.30
122	Тусламжийн орлого	-	5,490,199,087.74
1221	Хандив тусламж / дотоод/	-	5,490,199,087.74
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,712,533,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	3,712,533,400.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,488,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,488,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,030,235,037.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,098,120,100.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,098,120,100.00	-

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	797,045,250.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	797,045,250.00	-
1330	Төсвийн захирагчдаас	135,069,687.00	-
133003	Хөрөнгийн	135,069,687.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,256,160,163.78	5,526,210,948.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,256,160,163.78	5,526,210,948.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,254,846,612.71	5,193,320,757.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,422,916,000.00	2,261,971,785.57
210101	Үндсэн цалин	1,226,546,866.94	1,752,824,644.68
210102	Нэмэгдэл	11,230,182.52	40,960,045.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,592,450.54	149,960,000.00
210104	Урамшуулал	116,130,000.00	318,227,094.92
210105	Гэрээт ажлын хөлс	2,416,500.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,989,500.00	257,588,176.53
210201	Тэтгэврийн даатгалын зардал	117,633,600.00	173,165,071.29
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	13,839,100.00	21,668,152.79
210203	ҮОМШӨ- ний даатгалын зардал	6,920,000.00	12,932,189.36
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	6,919,500.00	9,826,125.38
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	27,677,300.00	39,996,637.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	688,329,440.00	324,670,458.83
210301	Гэрэл, цахилгаан	-	6,071,285.83
210304	Байрны түрээс	688,329,440.00	318,599,173.00
2104	Хангамж, бараа материалын зардал	283,213,959.17	226,999,870.21
210401	Бичиг хэрэг	53,617,745.61	35,575,388.10
210402	Тээвэр, шатахуун	59,574,207.00	24,653,253.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,195,042.33	11,697,877.51
210404	Ном, хэвлэл	92,007,470.23	138,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	68,819,494.00	117,067,412.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	37,867,339.00
2105	Нормативт зардал	-	16,166,960.00
210502	Хоол, хүнс	-	16,166,960.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,000.00	8,000,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	840,000.00
210604	Урсгал засвар	30,000.00	7,160,600.00
2107	Томилолт, зочны зардал	315,051,038.60	106,344,796.46

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210701	Гадаад албан томилолт	272,678,038.60	35,926,137.82
210702	Дотоод албан томилолт	42,373,000.00	70,418,658.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	318,113,500.00	1,882,505,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	295,239,100.00	1,870,026,640.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,874,400.00	7,478,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,203,174.94	109,072,969.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	14,480,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,203,174.94	94,592,969.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,313,551.07	332,890,191.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	332,890,191.85
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	332,890,191.85
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	332,890,191.85
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	332,890,191.85
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,313,551.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	750,547.07	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	563,004.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)- (II)	99,424,862.70	117,861,562.17
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	99,424,862.70	117,861,562.17

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	23,546,173,026.45	5,492,348,186.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	221,136,910.20	5,492,348,186.74
120	Нийтлэг татварын бус орлого	75,902,110.20	291,814,786.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	560,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	560,000.00
120009	Бусад орлого	75,902,110.20	291,254,786.74
122	Тусламжийн орлого	145,234,800.00	5,200,533,400.00
1221	Хандив тусламж /дотоод/	145,234,800.00	5,200,533,400.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	3,712,533,400.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	3,712,533,400

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,488,000,000.00
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,488,000,000.00
122001	Бусад хандив тусламж /дотоод/	145,234,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,325,036,116.25	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,337,402,866.25	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,098,120,100.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	239,282,766.25	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	797,045,250.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	797,045,250.00	-
1330	Төсвийн захирагчдаас	20,190,588,000.00	-
133003	Хөрөнгийн	20,190,588,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,206,641,380.20	5,403,035,978.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,206,641,380.20	5,403,035,978.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,205,327,829.13	5,070,145,786.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,422,916,000.00	2,191,335,862.10
210101	Үндсэн цалин	1,226,546,866.94	1,705,248,474.96
210102	Нэмэгдэл	11,230,182.52	39,981,901.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,592,450.54	149,515,360.87
210104	Урамшуулал	116,130,000.00	296,590,124.97
210105	Гэрээт ажлын хөлс	2,416,500.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,989,500.00	328,224,100.00
210201	Тэтгэврийн даатгалын зардал	117,633,600.00	223,192,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	13,839,100.00	26,257,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	6,920,000.00	13,129,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	6,919,500.00	13,129,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	27,677,300.00	52,515,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	688,329,440.00	324,670,458.83
210301	Гэрэл, цахилгаан	-	6,071,285.83
210304	Байрны түрээс	688,329,440.00	318,599,173.00
2104	Хангамж, бараа материалын зардал	249,192,510.56	110,797,066.11
210401	Бичиг хэрэг	39,751,540.00	30,657,969.00
210402	Тээвэр, шатахуун	59,574,207.00	24,798,253.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,195,042.33	12,972,877.51
210404	Ном, хэвлэл	106,672,170.23	1,598,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,999,551.00	40,769,366.00

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	9,605,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,605,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	18,479,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	9,307,950.00
210604	Урсгал засвар	-	9,171,250.00
2107	Томилолт, зочны зардал	315,051,038.57	106,344,796.46
210701	Гадаад албан томилолт	272,678,038.60	35,926,137.82
210702	Дотоод албан томилолт	42,372,999.97	70,418,658.64
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	347,244,340.00	1,980,491,303.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	324,369,940.00	1,972,960,003.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	22,874,400.00	7,531,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,803,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,803,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,313,551.07	332,890,191.85
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	332,890,191.85
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	332,890,191.85
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	332,890,191.85
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	332,889,554.85
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	637.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,313,551.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	750,547.07	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	563,004.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	20,339,531,646.25	89,312,208.39
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	101,464,480.00	109,684,555.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,464,480.00	109,684,555.00
2200	Дотоод эх үүсвэрээр	101,464,480.00	109,684,555.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,464,480.00	109,684,555.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-101,464,480.00	-109,684,555.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	20,238,067,166.25	-20,372,346.61
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	20,238,067,166.25

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,238,067,166.25	20,217,694,819.64
----	---	-------------------	-------------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	394,352,450.14	394,352,450.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	70,000.00	70,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	394,422,450.14	394,422,450.14
9	Тайлант үеийн үр дүн	-	-	99,424,862.70	99,424,862.70
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	493,847,312.84	493,847,312.84
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	493,847,312.84	493,847,312.84
19	Тайлант үеийн үр дүн	-	-	117,861,562.17	117,861,562.17
20	2025 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	-	-	611,708,875.01	611,708,875.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Татаас, санхүүжилтийн орлого	4,171,242,900.00	3,380,203,845.15	791,039,054.85	81.0
12	Улсын төсвөөс	4,171,242,900.00	3,379,643,845.15	791,599,054.85	81.0
122	Урсгал	4,171,242,900.00	3,379,643,845.15	791,599,054.85	81.0
	Бараа, үйлчилгээний орлого	-	560,000.00	(560,000.00)	-
12004	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	-	560,000.00	(560,000.00)	-

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,171,242,900.00	3,380,763,845.15	790,479,054.85	81.0
	Ажиллагчидтай холбогдсон зардал	2,954,016,500.00	2,519,559,962.10	434,456,537.90	85.3
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	2,625,792,400.00	2,191,335,862.10	434,456,537.90	83.5
210101	Цалин	2,165,520,500.00	1,705,248,474.96	460,272,025.04	78.7
2102	Цалингийн тусгай нэмэгдлүүд	460,271,900.00	486,087,387.14	(25,815,487.14)	105.6
	Нийгмийн хамгааллын шимтгэл	328,224,100.00	328,224,100.00	-	100.0
210201	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	275,708,300.00	275,708,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	52,515,800.00	52,515,800.00	-	100.0
	Бараа, үйлчилгээний урсгал зардал	1,035,439,400.00	843,983,078.05	191,456,321.95	81.5
210301	Гэрэл цахилгааны зардал	9,994,500.00	6,071,285.83	3,923,214.17	60.7
210304	Байрны түрээс	315,828,000.00	318,599,173.00	(2,771,173.00)	100.9
210401	Бичиг хэргийн материал	47,632,600.00	30,657,969.00	16,974,631.00	64.4
210402	Тээвэр, шатахууны зардал	28,798,300.00	22,798,253.60	6,000,046.40	79.2
210403	Шуудан холбооны зардал	22,482,000.00	12,533,977.51	9,948,022.49	55.8
210702	Дотоод томилолтын зардал	74,460,900.00	67,831,555.09	6,629,344.91	91.1
210701	Гадаад томилолтын зардал	39,216,600.00	21,765,485.02	17,451,114.98	55.5
210404	Ном, хэвлэлийн зардал	1,598,600.00	1,598,600.00	-	100.0
210406	Жижиг эд хогшил худалдан авах зардал	45,591,400.00	40,769,366.00	4,822,034.00	89.4
210801	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	373,751,500.00	252,531,863.00	121,219,637.00	67.6
210809	Маягт хэвлүүлэх зардал	7,531,300.00	7,531,300.00	-	100.0
210604	Урсгал засварын зардал	13,500,000.00	9,171,250.00	4,328,750.00	67.9
210901	Бусад зардал	9,803,000.00	9,803,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	45,250,700.00	42,320,000.00	2,930,700.00	93.5
	Хөтөлбөр арга хэмжээний зардал	-	-	-	-

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Хөрөнгийн бусад зардал	181,787,000.00	16,660,805.00	165,126,195.00	9.2
	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	4,171,242,900.00	3,380,203,845.15	791,039,054.85	81.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	121	121	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60	41	19	68.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	59	40	19	67.8
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	60	41	19	68.3
650013	Шатлалгүй цалин	60	41	19	68.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,488,000,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,488,000,000.00
122	Тусламжийн орлого	1,488,000,000.00
1221	Хандив тусламж / дотоод/	1,488,000,000.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,488,000,000.00
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,488,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,487,999,363.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,487,999,363.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,487,999,363.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,487,999,363.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,487,999,363.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	637.00
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-637.00
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-637.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хархорум хотын Захирагчийн ажлын албаны эрхэм зорилго нь түүхэн нийслэл Хархорум хотыг хот байгуулалтын орчин үеийн шинэлэг арга барил, хүн төвтэй засаглалын хандлага, технологийн дэвшилтэт шийдлүүдийг ашиглан, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцүүлэн сэргээн байгуулахад оршино.

Хархорум хотын Захирагчийн ажлын алба үйл ажиллагааны чиглэлээ “*Шинэ Хархорум хот байгуулахад шаардлагатай төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах, эрх зүй, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, менежментээр хангах*” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хархорум хотын Захирагчийн ажлын алба үйл ажиллагаандаа Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль Хот байгуулалтын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 136 дугаар тогтоол болон бусад дүрэм, журмыг мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Хархорум хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, хөгжлийг дэмжих тухай хууль шинээр гарсан,
- Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн "Бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 136 дугаар тогтоол шинээр гарсан,
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам” батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ. Дотоод аудитыг хангалттай түвшинд гүйцэтгэсэн боловч өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг гадны хүнд захиалгаар хийлгэсэн боловч батлаагүй, шаардлага хангахгүй, ашиглалтгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29,689.6 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,238,067.2	20,217,694.8	(20,372.3)
Авлага	3,956.2	3,956.2	-
Бараа материал	145,642.2	28,888.2	(116,754.0)
Үндсэн хөрөнгө	296,769.7	463,585.6	166,815.9
Нийт хөрөнгө	20,684,435.3	20,714,124.9	29,689.6
Өр төлбөр	20,190,588.0	20,102,416.0	(88,172.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	493,847.3	611,708.9	117,861.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	20,684,435.3	20,714,124.9	29,689.6

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 28,888.2 мянган төгрөг болж, 116,754.0 мянган төгрөгөөр буурсан нь 118,455.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 52,101.5 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн бүртгэсэн, 114,793.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 172,517.5 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 463,585.6 мянган төгрөг болж, 166,815.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан 109,684.5 мянган төгрөг, шилжүүлэн бүртгэсэн 151,724.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 40,421.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэж, тайлант онд тооцсон 94,592.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсантай холбоотой.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 20,102,416.0 мянган төгрөг болж, 88,172.0 мянган төгрөгөөр буурсан нь Барьцаа хөрөнгийн данснаас 93,172.0 мянган төгрөгийн барьцаа чөлөөлж, аудитын төлбөр 5,000.0 мянган төгрөгийг нэмж бүртгүүлэн залруулга хийлгэсэнтэй холбоотой байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 611,708.9 мянган төгрөг болж, 117,861.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Биет бус хөрөнгөд нийт 10,210.2 мянган төгрөгийн Байгууллагын Веб Сайт, төсвийн программ, цаг бүртгэл систем, санхүүгийн тайлангийн программ нийт 4 программ хангамж бүртгэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 4,410,706.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 47,083.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 221,040.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 31,866.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 77,328.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 192,085.2 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 60,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 404,023.6 мянган төгрөг, байгууллага сурталчлах, сонсох үйл ажиллагааны зардлыг 80,000.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 30,000.0 мянган төгрөг, нийт 607,179.5 мянган төгрөгөөр бууруулж, 3,803,526.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Анхны батлагдсан төсвөөс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 1,151,556.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 29,525.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 227,723.4 мянган төгрөг, томилолт зочны зардлыг 240,539.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 279,023.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,173.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж, нийт 367,716.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 4,171,242.9 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,171,242.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,713,093.4 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 434,456.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 1,152.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 37,744.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 214,705.6 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 24,080.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 78,899.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
71503	Хот суурингийн ерөнхий төлөвлөлт	4,171,242.9	3,713,093.4	458,149.5	89.0
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3,876,752.9	3,418,603.4	458,149.5	89.0
80103	Гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	294,490.0	294,490.0	-	100.0

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Тайлант онд тус байгууллагын батлагдсан бүтэц, орон тоог 23.4 хувиар бууруулж цомхотгоогүй бөгөөд Хархорум хотын төлөвлөлт бүтээн байгуулалтыг дэмжих тухай хуулийн 15.2, Төсвийн тухай хуулийн 16.5-д заасныг тус

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

тус үндэслэн батлагдсан орон тоо 60, гүйцэтгэлээр 46 орон тоотойгоор ажилласан байна.

Унаа хоолны хөнгөлөлт: Хархорум хотын захирагчийн 2025.03.24-ний А/02 тоот Хоол унааны зардлыг тогтоох тухай захирамж нь хоол, унааны зардлыг ажлын нэг өдөрт 15.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Албан томилолт: МУ-ын ЗГХЭГ-ын даргын 2025.08.25-ны өдрийн 98 тоот тушаал, 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/33 тоот тушаалаар БНСУ-ын Сэжон хот руу Захирагч, 2025 оны 11 дүгээр 24-ны өдрийн А/60 тоот тушаалаар БНСУ-ын Инчеон хот руу мэргэжилтэн, 2025 оны 10 дугаар 12-ны А/46 тоот тушаалаар Япон улсын Тоёота хот руу мэргэжилтэн тус тус явж, гадаад томилолтын зардалд нийт 39,216.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Монголын төрөөс Хархорум хотыг дахин бүтээн босгож хөгжүүлэх түүхэн шийдвэр гаргалаа сэдэвт нэвтрүүлэг №23 тоот гэрээ 10,000.0 мянган төгрөг, Хархорум хотын төлөвлөлт бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг харуулсан цуврал сошиал контент, сурталчилгаа лайв ярилцлага тэмдэглэл №25/07/131/50 тоот гэрээ 19,000.0 мянган төгрөг, Хархорум хотын бүтээн босголт түүхэн замнал сэдэвт эрдэм шинжилгээний уулзалт хэлэцүүлэг №24 тоот гэрээ 10,000.0 мянган төгрөгөөр нийт 39,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 1,488,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч, 1,487,999.4 мянган төгрөгийг зарцуулалт хийж, 0.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэл /мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	"Хархорум" хотын төв цэг төв талбайн тохижилтын эхний ээлжийн ажил	2025-2026	"Хархорум" хотын төв цэг төв талбайн тохижилтын эхний ээлжийн ажил хийгдсэн байна.	Ажлын зураг төсөл батлагдсаны дараа тохижилтын ажил 2026 онд эхлэхээр болсон.	18,483,370.0	-
2	"Хархорум" хотын төв цэг	2025-2026	"Хархорум" хотын төв цэг	Эхлэлийн тайланг 2025.12.08-ны өдөр	1,516,630.0	-

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	төв талбайн тохижилтын зураг төсөл		төв талбайн тохижилтын зураг төсөл хийгдсэн байна.	ирүүлсэн. Нийт гүйцэтгэлийн 45 хувийн санхүүжилт авахаар хүлээгдэж байна.		
--	------------------------------------	--	--	---	--	--

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд нийт 20,156,004.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 8 бараа, ажил, үйлчилгээг, үүнээс нээлттэй тендер шалгаруулалтаар 2, харьцуулалтын аргаар 3, шууд худалдан авалтаар 3 худалдан авахаар төлөвлөснөөс 47,140.0 мянган төгрөгийн 2 ажил амжилттай хэрэгжиж дууссан 2, хэрэгжих шатандаа үргэлжилж буй 2, тендер зарлагдсан боловч цуцлагдсан 2, хэрэгжилтийн үе шатнаас шалтгаалан хойшлогдсон 1, цуцлагдсан 1 байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Хархорин хотын захирагчийн ажлын алба, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой, эрх мэдлийн давхцал үүсэж, санхүүгийн шийдвэр дээр хяналтын зарчим алдагдах эрсдэл үүсэх, ТАЦС-д "ангилалгүй" гэсэн ангилалтай байгааг шийдвэрлүүлэх, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу урамшууллыг олгож байх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах, НБББББ-ийг шаардлагын хэмжээнд боловсруулан, мөрдөж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Анализ старт аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудитор Д.Энхцаг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Н.Энхтуяа, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Лхагвацэнд, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны дүгээр 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/76 дугаар албан бичгээр ирүүлсэн боловч шаардлага хангахгүй байсан учир буцаасан бөгөөд 2026 оны дүгээр 02 дугаар сарын 11-ний өдөр зассан тайланг ирүүлсэн нь хуулийн хугацаанаас 17 хоног хоцроож, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын дагуу хөрвүүлж өгөөгүй, журналууд болон анхан шатны баримтыг мөн хоцроож ирүүлсэн, аудит хийх хугацаанд ерөнхий нягтлан бодогч 3 удаа солигдсон зэрэг нь аудит хийхэд хүндрэл үүсгэсэн болно.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг нийт зардлын 3,256,160.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 32,561.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Нийт 60, үүнээс удирдлага 4, гүйцэтгэх ажилтан 56 орон тоо батлагдсан ба оны дундуур ажилтнуудын тоо нэмэгдсээр жилийн эцэст 41 орон тоотой болсон байна. Нийт 6 ажилтан гадаад томилолтоор явсан бөгөөд үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ХК -ийг сонгож үйлчлүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 574,133.9 мянган төгрөгийн зөрчлөөс 574,133.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих орлого, зарлагын нийт 118 ажил гүйлгээний 10,721,730.2 мянган төгрөгийн мэдээллээс 16 ажил гүйлгээний 23,873.2 мянган төгрөгийн мэдээлэл, 550,260.8 мянган төгрөгийн бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр 60 шийдвэр, Худалдан авалтын төлөвлөгөө байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44.4."Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хархорум хотын Захирагч Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг үндэслэн 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 03 дугаар захирамж гарган зарлагын гүйлгээ хийх 1 дүгээр гарын үсэг зурах эрхийг шилжүүлсэн байна. Уг захирамж нь Төсвийн тухай хуулийн 14.1.22., 16.4.20 заалтуудтай нийцэхгүй бөгөөд Эрхээ шилжүүлсний дараа хөрөнгө зарцуулах 13 захирамж гаргасан нь эрх мэдлийн давхцал үүсэж, санхүүгийн шийдвэр дээр хяналтын зарчим алдагдах эрсдэл үүсэхээр байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.1."Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна." 14.1.22."улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны Захирагч тухайн шатны төсвийн". /Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./, 14.4."Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.", 16.4."Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна." 16.4.20."улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, улсын зэрэглэлтэй хотын хороолол, тосгоны ажлын албаны дарга тухайн шатны төсвийн." /Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө/ гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх мэдлийн давхцал үүсэж, санхүүгийн шийдвэр дээр хяналтын зарчим алдагдах эрсдэл үүсэхээр байгаа зөрчлийг арилгах зөвлөмж өгөв.

Тус байгууллага нь "Төрийн байгууллага, албан газар" гэсэн хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэртэй бөгөөд улсын төсвөөс санхүүждэг. Захирагчийн 2025 оны А/01 захирамжаар албан тушаалын үндсэн цалингийн хэмжээг тогтоосон бөгөөд ТАЦС-д "ангилалгүй" гэж Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан цалингийн сүлжээг үндэслээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хууль 3а ийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтууд, Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолтой нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: "Төрийн байгууллага, албан газар"-ын хувьд цалингийн хэмжээг Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолтой нийцүүлэх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, бүх дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 357,397.5 мянган төгрөгийн 20 алдааг залруулсан. НБББББ шаардлага хангахгүй байгааг сайжруулах талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй учир жилийн эцсийн зөрчилд оруулав.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага, давтан гаргахгүй байх 21,232,399.4 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт 87.5 хувьтай байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	0.0	1	0.0	100.0
Зөвлөмж	4	21,232,399.4	3	21,232,399.4	75.0
Нийт дүн	5	21,232,399.4	4	21,232,399.4	87.5

Шилэн дансанд мэдээлэл бүрэн байршуулаагүйд өгсөн зөвлөмж, албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг тогтоосон шийдвэр нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан цалингийн сүлжээг үндэслээгүй байгааг дээд шатны аудитад тусгах гэсэн шийдвэр хэрэгжээгүй, тайлант онд давтагдсан байна. Тайлант онд Шилэн дансанд мэдээлэл бүрэн байршуулаагүй зөрчилд албан шаардлага, албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг тогтоосон шийдвэр нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан цалингийн сүлжээг үндэслээгүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй “Acolous” програмыг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан журам, санхүүгийн тайлангийн маягттай нийцүүлэх .

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 109,946.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 109,946.0 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Барьцаа хөрөнгийн данснаас 93,172.0 мянган төгрөгийн барьцаа чөлөөлөхдөө өглөг бууруулж бичилт хийлгүй шууд зардалаар тайлагнасан нь УСНББОУС 1, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй;
- 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын ажлын гэрээний 5,000.0 мянган төгрөгийн төлбөрийг төлөөгүй, тооцоо нийлж, өглөгөөр бүртгээгүй нь УСНББОУС 1, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Захиалагчийн хяналтын урамшуулал, урамшуулалт цалин 11,771.0 мянган төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулалгүй бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд шууд бичсэн нь УСНББОУС 1, “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 246,196.1 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 57,817.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 141,355.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 47,022.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 246,196.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 213,634.5 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Үр дүнгийн урамшууллыг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 32 ажилтанд бүтэн 1 сарын цалинтай тэнцүү дүнгээр олгосон нь 2023 оны 3 дугаар сарын 3-нд олгогдсон Монгол улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийг “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ГАЗАР” гэснийг болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар”, 14 дүгээр зүйлийн 14.1. “Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2. “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.”, тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.4 “улирал тутам ажлын үр дүн, бүтээмжийг харгалзан үндсэн цалингийн 50 хувь хүртэл урамшуулал олгож болно” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үр дүнгийн урамшууллыг холбогдох эрхийн актуудыг зөрчин илүү олгосон зөрчилд төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 136 дугаар тогтоолын 04 дүгээр заалтын дагуу Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанд шилжүүлсэн бөгөөд Хархорум хотын Захирагчийн ажлын албаны Улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр олгоогүй, зөвхөн оноосон нэр өөрчлөгдсөн болон Захирагчийг томилогдсоныг бүртгэсэн байна. Гэтэл Захирагчийн 2025 оны 03 дугаар сарын 24-ний 30, 31, 32, 2025 оны 04 дүгээр сарын 04-ний 36 дугаар захирамжуудаар “Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа татан буугдсантай холбогдуулан” гэж өмнөх дарга, ерөнхий менежер, ерөнхий инженер, даргын жолооч /уг албан тушаалууд хэвээр байгаа болно/ гэсэн 4 хүнд Хөдөлмөрийн тухай хуулийн 60.3, 82.1.2, Хөдөлмөрийн дотоод журмын **холбогдох** заалтыг /2025 оны 03 дугаар сарын 24-нд уг журам гараагүй

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байсан ба 2025 оны 04 дүгээр сарын 04-нд А/12 дугаар захирамжаар батласан/ үндэслэн 1-4 сарын цалинтай тэнцэх тэтгэмжийг цалингийн зардлаас олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэжүүлж, тайлагнах" гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг зөрчин, цалингийн зардлаас тэтгэмж олгосон зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах сошиал контент бэлтгэн шууд лайваар дамжуулах үйлчилгээ авахаар 1 захиралтай 2 хуулийн этгээдтэй төсөвт өртгийг хуваан нийт 39,000.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно., 31 дүгээр зүйлийн 31.1.Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна: заалтуудтай тус тус нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчин, төсөвт өртгийг хуваан шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 "Хархорум хотоо хамтдаа бүтээе" арга хэмжээг зохион байгуулахаар 2 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж нийт 36,155.0 мянган төгрөгийн /Мандала тайгер армо ХХК-д 19,700.0 мянга, Мойлт ундарга ХХК-д 16,455.0 мянга/ үйлчилгээ авч, гүйцэтгэлийн тайлан акт үйлдсэн боловч, хичнээн хүн оролцсон ямар үйлчилгээнд хэдэн төгрөг зарцуулсан төсөв, гүйцэтгэлийн анхан шатны нотлох баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх; заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчин, анхан шатны баримтгүй гүйлгээ хийж, зардалд бүртгэдэг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.2.4 Хархорум хотын бүтээн байгуулалттай холбоотой үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор 4 босоо дэлгэц, 3 ухаалаг дэлгэц түрээслэн түрээсийн төлбөрт 18,900.0 мянган төгрөгийг төлж, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэжүүлж, тайлагнах"; гэсэн заалттай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг зөрчин, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулдаггүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас буцалтгүй тусламж, нэг удаагийн тэтгэмжинд 13,062.7 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”; 41 дүгээр зүйлийн 41.2.2” *батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*”; 41.2.3 “*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*” гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, цалингийн зардлаас буцалтгүй тусламж, нэг удаагийн тэтгэмж олгохгүй байх.

2. Томилолтын зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Давхардсан тоогоор 200 хүн томилолтоор ажиллаж, 33,960.0 мянган төгрөгийг томилолтын зардалд зарцуулж, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байгаа нь */Жилд дунджаар цалин авсан 36 ажилтан байх бөгөөд 1 хүн 5.5 удаа томилолтоор явсан гэж харагдаж байна/* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.”*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*” гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Томилолтын үр дүнг үнэлж, томилолтын зардлыг хэмнэлттэй зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

3. Тооцоо нийлсэн асуудалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан гаргахад эрсдэлтэй гэж үзэж буй харилцагчид болон олон удаагийн гүйлгээтэй харилцагчидтай тайлант хугацааны эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.”*Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлан гаргахад эрсдэлтэй гэж үзэж буй харилцагчид болон олон удаагийн гүйлгээтэй харилцагчидтай тайлант хугацааны эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

4. НБББББ-тэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах ажлыг гадны хүнд захиалгаар хийлгэсэн боловч уг баримт бичиг нь шаардлага хангахгүй, ашиглалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.”*төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”; 41.2.2.”*батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*”; 41.2.3.”*төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах*” гэж заасантай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өмнө хийсэн газраар үнэ төлбөргүй, нэмэлт зардал төсвөөс гаргахгүйгээр шаардлага хангахуйц түвшинд хийлгүүлэн, мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Барьцаа хөрөнгийн данснаас барьцаа чөлөөлөхдөө өглөг бууруулж бичилт хийлгүй шууд зардалаар тайлагнасан.	1	93,172.0					1	93,172.0				
2	Аудитын төлбөрийг төлөөгүй, өглөгөөр бүртгээгүй.	1	5,000.0					1	5,000.0				
3	Захиалагчийн хяналтын урамшуулал, урамшуулалт цалинг зардалд шууд бичсэн.	1	11,774.0					1	11,774.0				
	Дүн	3	109,946.0					3	109,946.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал	
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Тоо	Дүн
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо		
1	Өмнөх дарга, ерөнхий менежер, ерөнхий инженер, даргын жолооч нарт 1-4 сарын цалинтай тэнцэх тэтгэмжийг цалингийн зардлаас олгож, төсвийг зориулалт бус зарцуулсан.	1	48,000.0			1	48,000.0							
2	ҮДУ-ыг 202512.30-нд 32 ажилтанд 100.0%-иар олгосон	1	57,817.9	1	57,817.9									
3	Цалингийн зардлаас буцалтгүй тусламж, 1 удаагийн тэтгэмж олгосон.	1	13,062.7					1	13,062.7					
4	Давхардсан тоогоор 200 хүн томилолтоор ажиллаж, 33,960.0 мянган төгрөгийг томилолтын зардалд зарцуулсан.	1	33,960.0					1	33,960.0					
5	Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах сошиал контент бэлтгэн	1	39,000.0			1	39,000.0							

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	шууд лайваар дамжуулах үйлчилгээ авахаар 1 захиралтай 2 хуулийн этгээдтэй төсөвт өртгийг хуваан нийт 39,000.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.											
6	"Хархорум хотоо хамтдаа бүтээе" арга хэмжээг зохион байгуулахаар 2 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж нийт 36,155.0 мянган төгрөгийн үйлчилгээ авч, зарцуулалтын баримтгүй.	1	36,155.0			1	36,155.0					
7	Хархорум хотын бүтээн байгуулалттай холбоотой үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор 4 босоо дэлгэц, 3 ухаалаг дэлгэц түрээслэн түрээсийн төлбөрт 18,900.0 мянган төгрөгийг төлсөн.	1	18,900.0			1	18,900.0					
8	Харилцагчидтай тайлант хугацааны эцэст тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулжуулаагүй.	1	0	0				1	0			
9	НБББББ боловсруулах ажлыг гадны хүнд захиалгаар хийлгэсэн боловч уг баримт бичиг нь шаардлага хангахгүй, ашиглалтгүй.	1	0	0				1	0			
	Дүн	9	246,196.1	1	57,817.9	4	141,356.2	4	47,022.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих орлого, зарлагын нийт 118 ажил гүйлгээний 10,721,730.2 мянган төгрөгийн мэдээллээс 16 ажил гүйлгээний 23,873.2 мянган төгрөгийн мэдээлэл, Төсөв мөнгө захиран зарцуулах 550,260.8 мянган төгрөгийн 60 шийдвэр, Худалдан авалтын төлөвлөгөө байршуулаагүй.	1	574,133.9	1	574,133.9		
	Дүн	1	574,133.9	1	574,133.9		
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						

Хархорин хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1	Захирагч эрхээ шилжүүлсний дараа хөрөнгө зарцуулах захирамж гаргасан нь эрх мэдлийн давхцал үүсэж, санхүүгийн шийдвэр дээр хяналтын зарчим алдагдах эрсдэл үүсэхээр байна.	1	0			1	0
2	Тус байгууллага нь "Төрийн байгууллага, албан газар" гэсэн хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэртэй бөгөөд улсын төсвөөс санхүүждэг. Захирагчийн 2025 оны А/01 захирамжаар албан тушаалын үндсэн цалингийн хэмжээг тогтоосон бөгөөд ТАЦС-д "ангилалгүй" гэж Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор баталсан цалингийн сүлжээг үндэслээгүй.	1	0			1	0
	Дүн	2	0			2	0
	Нийт дүн	3	574,133.9	1	574,133.9	2	0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар

473/20250122

Улаанбаатар хот

СМ-0026/300/НА-СТА-ТМЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, сошиал контент бэлтгэн шууд лайваар дамжуулах үйлчилгээ авахаар 1 захиралтай 2 хуулийн этгээдтэй төсөвт өртгийг хуваан нийт 39,000,000.00 төгрөгийн шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", 31 дүгээр зүйлийн 31.1-д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна." гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхгүй, төсөвт өртгийг хувааж, харьцуулалтын аргаас зайлс хийж шууд гэрээ байгуулан, төсвийг зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 474/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/320/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Хархорум хотоо хамтдаа бүтээе" арга хэмжээг зохион байгуулахаар 2 хуулийн этгээдтэй гэрээ байгуулж нийт 36,155,000.00 төгрөгийн үйлчилгээ авч, гүйцэтгэлийн тайлан акт үйлдсэн боловч, хичнээн хүн оролцсон ямар үйлчилгээнд хэдэн төгрөг зарцуулсан төсөв, гүйцэтгэлийн анхан шатны нотлох баримтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх," гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлд анхан шатны болон дэмжих нотлох баримтын бүрдэлгүй, бүрэн бус хангалтгүй баримтыг үндэслэн гүйлгээ хийж, зардалд бүртгэдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ЭНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

ATA16087
9035021411

Z:\Alban Shaardlaga 2026\0125 SAG-83.Docx

1526181008



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 475/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/320/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаагаа сурталчилах зорилгоор 15 хоногт 4 босоо дэлгэц, 3 ухаалаг дэлгэц түрээслэн, түрээсийн төлбөрт 18,900,000.00 / арван найман сая есөн зуун мянган /төгрөгийг төлж, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.2.-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 476/A0150122

Улаанбаатар хот

САГ-2026/320/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

• Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 136 дугаар тогтоолын 04 дүгээр заалтын дагуу Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны төсөв, хөрөнгө, эрх, үүрэг, бүтэц бүрэлдэхүүнийг Хархорум хотын Захирагчийн ажлын албанд шилжүүлсэн бөгөөд Хархорум хотын Захирагчийн ажлын албаны Улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр олгоогүй, зөвхөн оноосон нэр өөрчлөгдсөн болон захирагчийг томилогдсоныг бүртгэсэн байна. Гэтэл Захирагчийн 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 30, 31, 32, 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 36 дугаар захирамжуудаар "Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа татан буугдсантай холбогдуулан" гэж өмнөх дарга, ерөнхий менежер, ерөнхий инженер, даргын жолооч /уг албан тушаалууд одоо хэвээр ажиллаж байгаа болно/ гэсэн 4 хүнд Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3, 82.1.2, Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг /2025 оны 03 дугаар сарын 24-нд уг журам гараагүй байсан ба 2025 оны 04 дүгээр сарын 04-нд А/12 дугаар захирамжаар батласан/ үндэслэн 1-4 сарын цалинтай тэнцэх 48,000,000.00(дөчин найман сая) төгрөгийн тэтгэмжийг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41.2.2."батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; 41.2.3."төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох," гэсэн заалттай тус тус нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.6 "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан", 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг, цалингийн зардлаас тэтгэмж олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-83.Docx

1526181012

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 477/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/320/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын 23,873, 200.00 /хорин гурван сая найман зуун далан гурван мянга хоёр зуун/ төгрөгийн 16 гүйлгээ мэдээлээгүй, Төсөв мөнгө захиран зарцуулах 550,260,800.00 /таван зуун тавин сая хоёр зуун жаран мянга найман зуун/ төгрөгийн 60 шийдвэр болон худалдан авалтын төлөвлөгөө байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана: ;" 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН,
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Н.ЭНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 86/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/320/НА.СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хархорум хотын захирагчийн ажлын албаны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үр дүнгийн урамшууллыг 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр 32 ажилтанд бүтэн 1 сарын цалинтай тэнцүү дүнгээр нийт 57,817,875.88 (тавин долоон сая найман зуун арван долоон мянга найман зуун далан таван төгрөг наян найман мөнгө) төгрөгийг шалгуур үзүүлэлтгүй хавтгайруулан олгосон.

Энэ нь 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр олгогдсон Монгол Улсын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хуулийн этгээдийн хариуцлагын хэлбэрийг "Төрийн байгууллага, албан газар" гэснийг болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.-д "Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: 1/ төрийн байгууллага, албан газар; 2/ төрийн өмчит үйлдвэрийн газар", 14 дүгээр зүйлийн 14.1.-д "Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.", тус байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 8.4-т "улирал тутам ажлын үр дүн, бүтээмжийг харгалзан үндсэн цалингийн 50 хувь хүртэл урамшуулал олгож болно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон", 4.2.3.8-т "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү тогтоож олгосон үр дүнгийн урамшууллын 57,817,875.88 (тавин долоон сая найман зуун арван долоон мянга найман зуун далан таван төгрөг наян найман мөнгө) төгрөгийг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт¹ ирүүлэхийг Хархорум хотын захирагчийн ажлын албаны дарга /Ч.Сайнбат/, ерөнхий нягтлан бодогч /Ц.Даваа-Өлзий/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АНАЛИЗ СТАРТ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Н.ЭНХТУЯА